

ОЮУТАН СОЛИЛЦОО (D 2 6)

ОЛГОХ ХҮРЭЭ:

Их, дээд сургуулиудын хооронд байгуулсан хөтөлбөрийн дагуу курс эсхүл хөтөлбөрт суралцахаар төлөвлөж буй иргэн.

Монгол Улсаас БНСУд суралцахыг төлөвлөж буй иргэн Солонгосын Виз Мэдүүлэх Төвөөр дамжуулан визээ мэдүүлнэ. Та 3 сарын хугацаанд хүчинтэй нэг удаагийн нэвтрэх эрхтэй виз мэдүүлж болох бөгөөд БНСУ-ын ЭСЯ аас нэмэлт бичиг баримтууд шаардаж болно. Визний мэдүүлэг нь дараах бичиг баримтуудын эх хувь болон хуулбарын хамт байна.

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Виз мэдүүлгийн маягт (Маягт 17) :Цээж зураг (3.5 x 4.5 см хэмжээтэй, сүүлийн 6 сарын дотор авахуулсан) визний хураамж 60 ам.доллар
2. Гадаад паспорт, хуулбарын хамт 1 хувь (Виз мэдүүлж буй өдрөөс хойш хамгийн багадаа 6 сарын хүчинтэй байх)
3. Элсэлтийн зөвшөөрлийн гэрчилгээ, Сургуулийн ААН гэрчилгээний хуулбар
4. Сургууль хооронд байгуулсан хэлэлцээрийн хуулбар, Солонгосын уригч их сургуулийн албан бичиг
5. Харъяа сургуулийн захирлын тодорхойлолт
6. Харъяа сургуулийн тодорхойлолт болон оюутны дүнгийн тодорхойлолт
7. Солонгосд амьдрах зардлыг батлан даах
 - * **Батлан даагч 1, 2:**
 - Батлан даагчийн иргэний үнэмлэхийн хуулбар болон төрөл садангийн лавлагаа
 - Гадаадад суралцах зардлыг даана гэсэн гар өргөдөл, ажлын газрын тодорхойлолт
 - Батлан даагчийн сарын орлогыг нотлох бичиг баримт (Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар болон лавлагаа, татварын тодорхойлолт г.м)
8. Гэрлэлтийн лавлагаа (сүүлийн 45 хоногт олгогдсон байх)
 - 19 нас хүрээгүй иргэний хувьд төрсний бүртгэлийн лавлагаа авах бөгөөд төрсний бүртгэлийн лавлагаа дээр эцэг эхийн төрсөн он сар өдөр тэмдэглэгдээгүй тохиолдолд эцэг эхийн иргэний үнэмлэхний хуулбар авчрах.
 - * **Гэрлэлтээ батлуулаагүй хүүхэдтэй иргэний хувьд хүүхдийн төрсний бүртгэлийн лавлагаа нэмэлтээр авах.**
9. Цагдаагийн газрын тодорхойлолт (Анх удаа виз мэдүүлж байгаа тохиолдолд, сүүлийн 45 хоногт олгогдсон байх)
10. Сүрьеэгийн шинжилгээ: (БНСУ-ын ЭСЯ-аас зөвшөөрөгдсөн эмнэлгээс авсан байх)
11. Хэлний түвшин нотлох бичиг баримт
 - * **Дүнгийн шалгуур үзүүлэлт:**
 - Солонгос хэл – Коллеж/МСҮТ: TOPIK 3-р түвшин**
 - Англи хэл: TOEFL 510**